

НЭГ СЭДЭВТ БҮТЭЭЛИЙН АНГЛИ ХУРААНГУЙД ХИЙСЭН СУДАЛГАА

С. Чимэдцогзол¹ доктор
МУИС, ШУС-ийн ГХТ

Д. Мөнхцэцэг²
МУИС, ШУС-ийн ГХТ

Д. Золжаргал³
МУИС, ШУС-ийн ГХТ

Abstract: *Scientific abstract is a brief summary of a research article, [thesis](#), review, [conference proceeding](#), or any in-depth analysis of a particular subject and is often used to help the reader quickly ascertain the paper's purpose. As such, an abstract is used by many organizations as the basis for selecting research that is proposed for presentation in the form of a poster, platform/oral presentation or workshop presentation at an [academic conference](#). Most literature database search engines index only abstracts rather than providing the entire text of the paper. Full texts of scientific papers must often be purchased because of copyright and/or publisher fees and therefore the abstract is a significant selling point for the reprint or electronic form of the full text. The abstract can convey the main results and conclusions of a scientific article but the full text article must be consulted for details of the methodology, the full experimental results, and a critical discussion of the interpretations and conclusions.*

Keywords: *abstracts, dissertations, science, scientific language, paragraph*

Өнөөгийн хүн төрөлхтөн нээн илрүүлсэн шинжлэх ухааны шинэ мэдлэг, мэдээлэл, технологийн шинэ ололт, дэвшлийн тухай мэдээллийг англи хэл дээр бичиж, дэлхийн мэдээллийн орон зайд харилцаж байна. Тухайлбал одоо интернетид “Шинжлэх ухаан”-“Scientific World” хаягаар орвол тэнд дотроо олон арван өгүүлэл, нийтлэл, илтгэл, лекц бүхий шинжлэх ухааны сэтгүүл, онол-практикийн хурлын эмхэтгэл гэх мэт 84000 гарчиг нээгдэнэ. (Durant John, Evans G. A. & Thomas G.P. (1989) “The Public Understanding of Science, Nature” 340: 11-14) Хүсвэл цаана нь үүнээс хэд дахин олон тооны эх сурвалж, ном бүтээлүүд нээгдэнэ. Энэ нь хүн төрөлхтний хөгжлийн өнөөгийн түвшинд юуны өмнө шинжлэх ухаан, технологийн мэдлэг, мэдээлэл даяарших учиртайг илэрхийлж байна.

Дэлхий нийтээр хэрэглэх бодит хэрэгцээ шаардлагын үүднээс авч үзвэл, шинжлэх ухаан, технологийн шинэ мэдлэг, мэдээллийг олж үзэх үгүйдээ л гэхэд шинжлэх ухааны өгүүлэл, нийтлэл, сонин, сэтгүүл, технологийн патент зэрэг нь олон улсын хэмжээнд системтэй дугаарлагдсан байх нь бүхий л улс түмний хөгжлийн хэрэгцээ шаардлага болсон байна. Энэ бүхэнтэй харилцан уялдаатайгаар, өдгөө Өрнө, Дорнын болон дэлхийн бүхий л улс түмний эрдэмтэн судлаачид, багш оюутнууд өөрсдийн шинжлэх ухааны бүтээлийг англи хэлээр хураангуйлан бичиж нийтийн хүртээл болгон түгээх, бусдын бүтээлээс тухайн хэлээр дамжуулан оюуны болон хөгжлийнхөө хэрэгцээ шаардлагыг хангаж байна. (Swales J. Genre analysis: English in academic and research settings. CUP Cambridge; 1990)

Хүн бүр шинжлэх ухааны бүтээлээ өөрийн төрөлх хэээр бичдэг атал яагаад заавал англи хэл дээр хөрвүүлэх ёстой юм бэ?, зөвхөн англи хэл нь шинжлэх ухааны хэл, хэллэг юм уу? гэх мэтийн асуулт маш олон давтагддаг. Тэгэхлээр, үүний учир шалтгааныг англи эх хэлний тогтолцоо, хэв маяг, шинжлэх ухааны хэллэгийн болон хэрэглээний онцлог зэрэг олон эерэг хүчин зүйлээр нотолж болдог. (Carter Sigglow J. Correspondence, Nature, 1996 Page 384)


Англи эх хэлний тогтолцоо, хэв маягыг Япон, Солонгос, Хятад зэрэг Азийн хэлнүүдтэй харьцуулбал ихээхэн ялгаатай. Өрнөдийнхний эх хэлнүүдийг өөр хооронд нь харьцуулбал дүрэм, үгсийн сангаас нь эхлээд өөр өөр тогтолцоо, хэв маягтай байдаг. Тиймээс хэл зүйн ухааны зарим судлаач, шинжлэх ухааны бүтээлийг зөвхөн төрөлх хэл дээрээ туурвих ёстой гэж үздэг. Гэтэл англи хэл нь шинжлэх ухааны хэл, хэллэгт бүрэн төгс нийцтэй гэж үздэг эрдэмтэн, судлаачид харьцангуй олон юм. Тиймээс өнөөгийн Герман, Франц гэх мэт олон улсын оюутнууд гадаад хэлний сонголтынхоо нэгдүгээрт нь англи хэлийг сонгон авдаг ажээ.

Шинжлэх ухааны бүтээлийн хураангуйг хятад хэлнээс хөрвүүлэхэд дээрх бэрхшээл тулгардаг байна. (Cline M. Implications for Anglo-German academic communications in English. *Strategies in world English* 1987, page 83) Гэхдээ, шинжлэх ухааны томоохон сэтгүүлд нийтэлсэн японы судлаачдын илтгэл, өгүүлэлд англи хэлний бичвэрийн асуудал үүсэхгүй байгаа нь шинжлэх ухааны хэл, хэллэг нийтлэг чанартай болохыг нэг талаар харуулж байгаа явдал болно. Өрнийн улс орнуудын эх хэлний хэв маягийг шинжлэх ухааны хэл хэллэгтэй илүү нийцтэй хэмээн үзэх хэрэгтэй. Учир нь эртний философийн нэр томъёо, танин мэдэхүйн онол арга зүйн нэрэлбэрүүд нь ихэвчлэн эртний Грек, Фини болон Англи, Франц, Испани, Герман хэлнээс гаралтай байна.

Шинжлэх ухааны англи хэл, хэллэг нь шинжлэх ухааны бүхий л салбарын эрдэмтэн судлаач нарын харилцааны чухал хэрэгсэл болж байгаа юм. Энэ бүхний эцэст дэлхий дахины шинжлэх ухааны хэл, хэллэгт шинжлэх ухааны англи хэлийг сонгон авсныг онцлон тэмдэглэж байна. Олон зууны турш шинжлэх ухааны үүднээс ажиглалт туршилт явуулсан болон хэрэглэж эхэлсний үр дүнд англи хэл шинжлэх ухаан танин мэдэхүйн ухагдахууныг шууд тусгаж илэрхийлэх өндөр ач холбогдолтой болохоо харуулсаар байна.(Cline M. Cultural differences in organization of academic texts: English and German. *Journal of Parametrics* 1987 Page 211)

Хураангуй буюу абстракт гэдэг нь (abstractum) гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд шинжлэх ухааны эх бичвэрийг хураангуйлж бичсэнийг хэлнэ. Хураангуй нь судлаачийн боловсруулсан арга зүй, эрдэм судлалын хэрэглэхүүн түүнд хийсэн ажиглалт дүгнэлт, дэвшүүлсэн асуудал, шийдвэрлэсэн байдал, туршиж нотолсон нотолгоо, зөвлөмж үр дүнг боловсруулсан байдал гэх зэрэг диссертацийн гол хэсгийн агуулгыг хураангуйлан нэгтгэж дүгнэсэн байдаг учир судалгааны ажлын иж бүрэн танилцуулга болдог.(Gliner, Jeffrey A.; Morgan, George A. (2000). *Research Methods in Applied Settings: An Integrated Approach to Design and Analysis*. Mahwah, NJ: Psychology Press.) Мөн хураангуй нь судлаачийн шинжлэх ухааны мэргэжлийн түвшин, ур чадварт үнэлгээ өгөх үндэслэл болдог албан ёсны хууль эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичиг юм.

Хураангуй нь дараах төрлүүдтэй байна. Үүнийг зургаар дүрслэн харуулбал:



Зураг1.1 Хураангуйн төрлүүд

Хураангуйг дотор нь:Тойм хураангуй-(Descriptive abstract), мэдээлэх хураангуй - (Informative abstract) гэж ангилдаг.(Finkelstein, Leo, Jr (2007). *Pocket Book of Technical Writing for Engineers and Scientists*. McGraw Hill. p 212–214.)

Тойм хураангуй (Descriptive)	Мэдээлэх хураангуй (Informative)
<p>Тойм хураангуйг ерөнхийдөө хүмүүнлэгийн болон нийгмийн шинжлэх ухааны баримт бичгүүд сэтгэлзүйн нийтлэлүүдэд хэрэглэдэг. Ихэнх тойм хураангуй нийтлэг тодорхой үндсэн хэсэгтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Оршил • Зорилго • Баримт бичгийн гол агуулагын тойм. <p>Тойм хураангуй тухайн судалгааны ажлын гол гол мэдээллүүдийг багтаадаг. Мөн тухайн судалгааны ажлыг шүүмжлэх өнцгөөс хардаггүй бөгөөд тухайн судалгааны ажлын гол үр дүн дүгнэлтийг оруулдаг. Тухайн өгөгдлийн түлхүүр үг болон зорилго, гол агуулгын тойм судалгааны арга, судалгааны хамрах хүрээ зэргийг мөн багтаадаг. Энэ нь маш богино хэмжээнд бичигддэг бөгөөд 50-100 с дэшгүй үгтэй байна.</p>	<p>Энэ нь маш түгээмэл хэрэглэгддэг хураангуйн нэг төрөл юм. Нийтлэг үндсэн хэсэгтэй байх бөгөөд тус бүр нэгээс хоёр өгүүлбэрээр байж болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Оршил • Судалгааны ажлын зорилго болон зорилт • Арга • Үр дүн <p>Шүүмжлэх буюу үнэлэх талаас нь бус тухайн судалгааны ажлыг дүрслэх талаас нь авч үздэг байна. Сайн бичигдсэн мэдээлэх хураангуй нь тухайн ажлыг орлож чаддагаараа онцлог юм. Зохиогч тухайн судалгааны гол чухал үндсэн асуудлууд түүний үр дүнг сайтар тусгадаг. Мөн тайлбарлаж дүрсэлсэн хураангуйн адил зорилго, судалгааны арга, хамрах хүрээг оруулахаас гадна үр дүн, судалгааны дүгнэлт, зохиогчийн саналыг ч мөн хамардаг. Хэмжээний хувьд тухайн хийсэн судалгааны ажлын 10 хувьтай тэнцэх бөгөөд 280 с дээш үгтэй байдаг.</p>

Хураангуй нь шинжлэх ухааны өгүүллийн үнэ цэнэ, зохиогчдын өгүүлэх санаа, хамрах хүрээ, хэлбэр, мэргэжлийн онцлог зэргээс шалтгаалан реферат хэлбэртэй байх нь элбэг байдаг. Энэ хэлбэр нь тухайн өгүүллийн бусдад хүргэх санаа, сонирхол, шийдвэрлэх асуудлыг уншигчдад ойлгоход илүү дөхөмтэй байхад тусалдаг.

Ямар ажлын талаар бичиж байгаагаас хамааран хураангуйн дотоод бүтэц ялгаатай байж болно. Шинжлэх ухааны ажлын хураангуй нь тухайн ажлын зорилго, хамрах хүрээ, агуулга болон үр дүнг багтаасан байдаг бол төслийн ажлын хураангуй нь тухайн ажлын үндсэн суурь болон төгсгөлийн үр дүнг агуулсан байна.


Хураангуй нь ОУ-ын түвшинд дараах хоёр төрөлтэй бичигддэг байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Effective abstract	Research abstract
<p>Хураангуй гэдэг бол тухайн бичсэн өгөгдлөөс уншигчдад ямар мэдээлэл чухал болох болон түүний ач холбогдлын талаар тусгаж өгдөг. Энэхүү төрлийн хураангуй нь 150-200 үгэнд багтах бөгөөд 4 гол үндсэн хэсэгтэй байна. Үүнд,</p> <ul style="list-style-type: none"> -Сэдвийн гол зорилго: Үүнд тухайн судалгааны гол санаа болон зорилгыг оруулдаг. -Судалгааны агуулга: Судалгааны ямар арга хэрэглэсэн, судалгаанд оролцсон хүмүүсийн тоо, судалгааны аргуудын жишээ, судалгааны загварууд тоон өгөгдлүүд зэрэг орно. Жишээ нь, энэхүү судалгааны ажилдаа 2031 жишээ түүсэн гэх мэт -Үр дүнг тайлбарлах -Үр дүнг гаргах, Тухайн онол болон таамаглалаар хир батлагдсан эсэх • this paper.....”, “this report.....” зэрэг болон үүнтэй ижил төстэй байдлаар өгүүлбэрийг эхэлж бичиж болохгүй ба судалгааны талыг илүү тусгасан нь зүйтэй • Шинжлэх ухааны бүтээлийн нэг хэсгээс хэсэгчлэн авч тайлбарлах • Өгүүлбэрээ төгсгөхдөө “.....is described”, “.....is reported”, “.....is analyzed” гэх зэргээр төгсгөхөөс зайлсхийх хэрэгтэй 	<p>Судалгааны хураангуй нь судалгааны хүрээнд буюу судалгааны төслийн явцыг товч гаргах зорилготой бичигддэг. Ерөнхийдөө гүйцэтгэсэн судалгааны товч хураангуй гэж ойлгож болно. Үүнийг маш сайн гүйцэтгэвэл таны судалгааны талаар уншигч илүү ихийг ойлгох хүсэлтэй болох юм. Зарим оюутнууд өөрсдийн судалгааны ололтыг тухайн бүс нутаг ба олон улсын хуралд хэлэлцүүлдэг. Research abstract нь ихэвчлэн оролцогчийн тухайн хурлын application-ны зарим хэсгүүдэд шаардагддаг. Үүний зарчмуудыг доор дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> • Motivation\problem statement- • Энэхүү асуудал нь хэрхэн чухал болох, шинжлэх ухааны, онолын, практикт тухайн судалгаанд ямар орон зай байгаа эсэх • Methods\procedure\approach-судалгааны арга, чиг хандлага • Тухайн судалгаанаас ямар үр дүн гарсан эсэх талаар, Жишээ нь, 3 зохиол дээр анализ хийсэн, 5 төрлийн тосны дээжийг ашигласан, 17 оюутнаас ярилцлага авсан гэх мэт • Results\finding\product- судалгааны явц • Тухайн судалгааны үр дүнд юуг шинээр бий болгосон, сурсан, бүтээсэн эсэх

<ul style="list-style-type: none"> • Мөн өгүүлбэрийг эхлэхдээ “it is suggested that...”, “it is believed that...”, “it is felt that...” гэх зэргээр эхэлж болохгүй. • Үгийг дахин давтах болон гарчигийг дахин дурдах хэрэггүй • Тухайн бүтээлд байхгүй мэдээллийг абстрактад оруулж болохгүй • Худалдааны нэрүүд, товчилсон болон хураангуйлсан үг, тэмдэгтүүдээс зайлсхийх, энэ тохиолдолд түүнийгээ тайлбарлах шаардлагатай бөгөөд энэ нь тухайн хураангуйг сунжруулах хандлагатай байдаг. 	<ul style="list-style-type: none"> • Conclusion\implication-судалгааны үр дүн • Уг судалгааг хийснээр олж авсан ололтууд, шийдлүүд зэрэг орно.
---	--

Шинжлэх ухааны өгүүллийн хураангуй нь бичлэгийн тодорхой бүтэцтэй байна. Жишээ нь: Европын шинжлэх ухааны редакторуудын зөвлөлөөс дараах бүтцийг санал болгодог.

- Судалгааны шинэлэг тал
- Судалгааны зорилго
- Судалгааны арга
- Судалгааны үр дүн
- Судалгааны онолын болон практик ач холбогдол
- Дүгнэлт



Зураг 1.2 Хүмүүнлэгийн шинжлэх ухааны хураангуйн бүтэц

гэсэн бүтэцтэй байдаг гэж University of North Carolina-гийн журамд тусгажээ.

Бид судалгааны ажлын хүрээнд ОУ-ын түвшинд судлаачид англи хэл дээр хураангуйг хэрхэн бичиж, боловсруулж байгааг судалсан бөгөөд тэдгээрээс зарим нэг улс орнуудын тухайд жишээлэн авч үзсэн болно. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Их, Британид	Австралид
-Background (content) тухайн сэдвийн ерөнхий зорилго болон агуулга, яагаад чухал болохыг тайлбарлах -Objectives: зорилгоо тодорхойлон бичих ба таамаглалыг энэ хэсэгт оруулж болно. -Design: тухайн судалгааны загвар болон уг судалгааг явуулсан хугацааг энд дурьдаж болно. -Setting: Хамрах хүрээ Тухайн судалгааг хаана явуулсан, хэдэн хүн оролцсон, тэднийг яаж сонгож авсан зэргийг энд бичнэ. -Intervention: уг судалгаанд хамрагдсан байгууллага болон хэрэглэсэн арга, хугацааг бичдэг.	-Зорилгоо зөв тодорхойлох -Зорилготойгоо хэрэглэж буй арга нь хэрхэн тохирох -Тулгамдаж буй асуудлууд -Сэдвийг судлахын ач холбогдол -Үгийн тооны хувьд 700-аас ихгүй байна.

-Main outcome measure: мэдээлэл цуглуулахаас өмнө төлөвлөж байсан судалгааны үр дүнгээ нотлох -Conclusions: Судалгааны үр дүнгээс гарсан дүгнэлт	
---	--

Хүснэгт 1.1 Хураангуй ОУ-ын түвшинд

Канад	Америк
-Канадын үндэсний архивын баталснаар магистрын судалгааны ажил нь 150 үгтэй харин докторын судалгааны ажил 350 үгтэй байдаг гэж тусгажээ. -Хураангуй нь бүх эх бичлэгийг илэрхийлж гаргах толь бөгөөд гол санаануудаа илтгэн гаргасан байна. -Таны судалгааны ажил таван бүлэгтэй гэж бодоход бүлэг тус бүрийг нэгээс хоёр өгүүлбэрээр нэгтгэн дүгнэн бичдэг.	-Motivation(problem statement)- Энэхүү асуудал нь хэрхэн чухал болох, шинжлэх ухааны, онолын, практикт тухайн судалгаанд ямар орон зай байгаа эсэх -Methods(procedure) approach-судалгааны арга, чиг хандлага Тухайн судалгаанаас ямар үр дүн гарсан эсэх талаар, Жишээ нь, 3 зохиол дээр анализ хийсэн, 5 төрлийн тосны дээжийг ашигласан, 17 оюутнаас ярилцлага авсан гэх мэт -Results (finding) product-судалгааны явц Тухайн судалгааны үр дүнд юуг шинээр бий болгосон, сурсан, бүтээсэн эсэх -Conclusion (implication)-судалгааны үр дүн Уг судалгааг хийснээр олж авсан ололтууд, шийдлүүд зэрэг орно.

Хүснэгт 1.2 Хураангуй ОУ-ын түвшинд

Оросын судлаач Е.В.Шапкина хураангуйг судалж:

- Хураангуйн хэмжээ болон утгат хэсгүүд
- Бичлэгийн зохион байгуулалт, утгат хэсгийн бүтэц
- Когезия буюу холбох хэрэгслүүд гэсэн агуулгын хүрээнд дүн шинжилгээ хийжээ.

Тэрээр 2014 онд хэвлэгдсэн математик, мэдээлэлзүй, эрчим хүч, хими, физик, төмөрлөгийн чиглэлийн өгүүлүүдийг сонгон авсан байна. Түүний үзсэнээр, хураангуй гэдэг нь шинжлэх ухааны хэл найруулгаар бичигдсэн зохиолчийн хэвлэл-болон гар бичмэлийн үндсэн гол санааг товчхон илэрхийлэх шинжлэх ухааны бичлэгийн нэг хэлбэр юм. Хураангуй нь өөрийн илэрхийлэх зорилгоосоо шалтгаалан

- дүрслэх,
- лавлах,
- рефератын,
- зөвлөх
- шүүмжлэх гэсэн хэлбэртэй байна гэж үзжээ.

Эрдмийн зэрэг горилогч хураангуйг тодорхой шаардлагын дагуу оновчтой нарийн дэс дараалалтай бичих шаардлагатай. Хураангуйг бичихдээ дараах хэд хэдэн зүйлүүдийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Эх бичвэрийг хэд хэдэн удаа уншсаны дараа бүлэг тус бүрийг нэгээс хоёр өгүүлбэрээр товч хураангуйлж бичнэ.
- Дараа нь эдгээр өгүүлбэрийг маш сайн уншиж гол санаагаа оруулсан эсэхээ сайтар шалгана.
- Тухайн бичиж буй хураангуй нь ямар төрөлд багтаж байгаагаас хамааран гол агуулгаа гаргана.
- Үгийн тоо чухал бөгөөд дахин шалгаж үг давталт, өгүүлбэрийн бүтэц зэргийг анхаарах хэрэгтэй.

Хураангуй нь санал өгч байгаа тодорхойлолт биш учраас ямар нэгэн үнэлгээг оруулахгүй байх нь зүйтэй. Хураангуйд үгсийг оновчтой сонгон бичсэнээр тайлбарлаж байгаа судалгааны ажлын талаарх гол ойлголтыг уншигчдад зөв хүргэх том гүүр болдог.

Үүнийг бичихдээ дараах нийтлэг зүйлүүдийг харгалзан бичих зайлшгүй шаардлагатай юм. Үүнд:

-Судалгааны ажлаа хураангуйлан бичихэд анхаарах ба судалгааны объект, судалгааны түүвэр, судалгааны аргууд, тухайн судалгаанд хэрэглэсэн онол, дүгнэлтийг нэгтгэх зэргийг анхаарах,

-Тухайн хийж буй судалгааны хэсэг бүрийн бусад судлаачдын судалгаандаа хэрэглэж болохуйц зүйлүүдийг нэгтгэн дүгнэх ба дахин нягталж дээрх санаагаа оруулах,

-Цэгцэлж бичсэнийхээ дараа тухайн судалгаанаас гадуурх судлаачдын үзэл бодлыг тусгах, давтагдсан үг байгаа эсэхийг шалгах, үүнд ижил утгатай болон нутгийн аялгууны үг хэллэгүүдийг шалгана.

-Логикийн зөв дараалалд товч хураангуй бичихийг анхаарах,

- “is”“are”, “appears to be” зэрэг үйл үгийг хэрэглэхээс илүүтэй “propose”, “report”, “analyze” зэрэг үйл үгүүдийг хэрэглэдэг.

Хашилт болон хоёрдмол утгатай үг хэллэгийг хэрэглэж болохгүй.

Өгүүлбэрийн бүтцийн хувьд нэр үг, үйл үг, нэр үг гэсэн бүтцийг өгүүлбэр бүрт хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй.

- Утга санааны хувьд уялдаа холбоо бүхий сайн бичсэн цогцолборууд /paragraph/

- Тухайн бичсэн сэдвийн гол санаа болон дүгнэлт нь тухайн article, paper, report-ийн зорилго, явц, үр дүн зэргийг үзүүлдэг.
- Тухайн article, paper, report-ийн цаг хугацааг хатуу нарийн дагаж баримтлах,
- Мэдээлэл хоорондын логик уялдаа холбоог сайн гаргасан байх,
- Шинэ мэдээлэл нэмэхгүйгээр энгийнээр нэгтгэн дүгнэх,
- Уншихад ойлгогдохуйц байх,
- Идэвхтэй үйл үгийг хэрэглэдэг бөгөөд мэдээллээ тодорхой болгоход онцгой анхаарах хэрэгтэй

Хураангуйг бичихдээ:

Судалгааны ажлын маш чухал хэсэг бол хураангуй юм. Судалгааны ажлын эхэн хэсэгт оршиж тухайн судлаачийн цаашдын бүтээлд юу өгүүлэх талаар товч дурддаг.

Хураангуй нь тухайн судалгааны ажлыг нэгтгэн дүгнэх ба тухайн сэдвийн маш чухал элементүүдийг багтаадаг бөгөөд зөвхөн оршил болон удиртгал хэсгийг биш тухайн судалгааны ажлыг бүхэлд нь товч хамруулдаг.

Хэмжээ болон бүтэц

Магистрын судалгааны ажлын хувьд 150 үгтэй, харин докторын судалгааны ажлын хураангуй 350 үгтэй байдаг.

Ер нь докторын судалгааны ажлын хураангуйг бичихдээ тухайн сэдвийн цар хүрээ, холбоо хамаарал зэргээс шалтгаалан сайтар хураангуйлж дунджаар 280 үгэнд багтаах нь нэн тохиромжтой байдаг.

Хураангуйн бүтэц нь тухайн судалгааны ажлын нэг үгээр хэлэхэд толь болж өгдөг ба гол бүтэц элементүүдийг тусгаж өгдөг. Жишээ нь: 5 бүлэгтэй судалгааны ажлын бүлэг бүрийг нэгээс хоёр өгүүлбэрээр товчхон илэрхийлж тусгана.

Хураангуй нь бие даасан, богино хэмжээний бүхэл бүтэн судалгааны ажлыг дүрсэлдэг томоохон өгөгдөл юм.

Хураангуй бичихэд дараах түгээмэл хэрэглэгддэг бүтцүүд байна. Үүнд:

Introduction (in present, present perfect, simple past tense)

- The purpose of this study is to investigate the effects of...on....
- The goals of this study are to determine....
- The primary purpose of this study is to determine...
- This study is specifically concerned with the effect of...on...
- This study is an initial attempt to investigate the relationship...
- This study has two major purposes: (1) to investigate(2) to demonstrate

Materials and methods (in past tense)

- This study was conducted at the National University of Mongolia.
- The empirical part of this study was conducted in May 2000.
- The subjects were randomly selected.
- The sample was selected from....
- Twenty companies served as subjects in a study designed to investigate....
- Six groups, each consisting of ..., were formed to....

Conclusions (in simple present or past tense)

- These results suggest that....
- The results show that / reveal....
- It was concluded that....
- This study / survey shows / supports / questions / implies / indicates....
- On the basis of the results of this research, it can be concluded that....
-

Further vocabulary

1. Verbs: show, demonstrate, illustrate, prove, argue, examine, explore, look into, consider, explore, look into, consider, deal with, address, involve, relate to, refer to, draw on, explain, investigate, highlight,

2. Nouns: intention, purpose, aim, objective, thesis, argument, issue, assumptions, methods, premises, results, conclusions, outcome, recommendations

3. Connecting words: however, first, second, then, finally, thus, for example, furthermore, in addition, in conclusion, by contrast, nonetheless, consequently,

Анкетын судалгаа

Бид судалгааны ажлын хүрээнд докторын диссертацийн хураангуйг англи хэл дээр хэрхэн бичиж байгааг судлаачдын хүрээнд анкетын аргаар судалсан болно. Шинжлэх ухааны зохиолын хэл найруулга, тэр дотроос эрдэм шинжилгээний нэг сэдэвт зохиолын хэл найруулга гэдэг өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой, тогтсон тодорхой зарчимтай, стандарт хэм хэмжээтэй байдгийг тодорхой тайлбарласан билээ. Эрдэм шинжилгээний зохиолын хэл найруулгын онцлогоос гадна тухайн салбар шинжлэх ухаан тэрчлэн нэг сэдэвт зохиолын сэдэв онцлог нь диссертаци түүний хураангуйн бичвэрт зохих хэмжээгээр нөлөөлдөг. Бидний судалгааны хувьд диссертацийн хураангуйг онцлон үзэж байгаа нь дараах учир шалтгаантай гэж хэлж болно. Үүнд:

1. Нэг сэдэвт зохиолыг бүрэн эхээр нь уншиж танилцах хүн маш цөөхөн зөвхөн албан ёсны шүүмжлэгчид, эксперт хийх эрдэмтэд болон санал өгөх хүмүүс л уншихаас бусад хүмүүс зөвхөн хураангуйг л уншиж танилцдаг.

2. Хураангуй нь судлаачийн боловсруулсан арга зүй, эрдэм шинжилгээний хэрэглэхүүн, түүнд хийсэн дүн шинжилгээ, судалгаа, дүгнэлт, дэвшүүлсэн асуудал, шийдвэрлэсэн байдал, туршилт нотолгоо, санал зөвлөмж гэх мэт зохиолын гол агуулгыг хураангуйлан нэгтгэсэн дэлгэрэнгүй танилцуулга болдог.

3. Хураангуй нь тухайн судлаачийн мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн түвшинд үнэлгээ өгөх албан ёсны үндэслэл болдог хууль эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичиг учраас эрдмийн зэрэг горилогч хураангуйн бичвэр хэл найруулгад онцгой анхаарал хандуулах ёстой гэж бид үзэж байгаа болно.

Нөгөө талаас хураангуйг боловсруулсан болон хэрэглэж байгаа хүмүүс нь бүгд эрдэм шинжилгээний хэл найруулгыг хэрэглэж харилцдаг нийгмийн бие даасан тодорхой бага бүлгийнхэн юм. Тиймээс зөвхөн энэ бичил бүлгийнхний санаа бодол, арга үйлдлийг социологийн судалгааны анкет, сурвалжлагын аргаар судлан бичиг баримтын шинжилгээний үр дүнтэй харьцуулан анализ дүгнэлт хийсэн болно.

Энэхүү социологийн бэсрэг судалгааг эрдэм шинжилгээний ажил хийж байгаа 150 эрдэмтэн судлаачдыг хамруулан явуулсан бөгөөд тэднээс ирүүлсэн анкетын анхдагч мэдээллээс шаардлага хангасан 133 анкетанд (SPSS) программ ашиглан боловсруулалт хийсэн болно. Судалгааны түүврийн онцлог, нийгэм-хүн ам зүйн шинжийг авч үзвэл: тэдний 33,9 % нь гуч хүртлэх насны залуучууд, 52,8% нь 30-50 хүртлэх дунд эргэм насныхан, 13,3% нь тавиас дээш насны ахмад эрдэмтэд байна. Судалгааны зарим үр дүнгээс дурдвал:



График1. Судалгаанд оролцогчдын нас

Судалгаанд хамрагдсан судлаачдыг хүйсийн хувьд 49,0% нь эрэгтэйчүүд, 51,0% нь эмэгтэйчүүд юм. Үүнийг графикаар харуулбал:



График2. Судалгаанд оролцогчдын хүйс

Судалгаанд давхардсан тоогоор нийт 29 мэргэжлийн салбарын, 33 төрлийн судалгааны чиглэлийн судлаач эрдэмтэд хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан судлаачдын 83,7% нь англи хэлээр, 16,3% нь орос хэлийг голлон хэрэглэж эрдмийн ажлаа хийдэг гэжээ. Үүнийг графикаар харуулбал:




График3. Судлаачдын эрдмийн ажлаа хийхэд хэрэглэж буй хэл

Судалгааны түүврийн талаарх энэ баримт нь манай шинжлэх ухааны салбарын бодит статистикээс хол зөрөхгүй, түүнийг төлөөлөх социаль чадвартай гэж үзэж болно.

Бидний судалгааны гол зорилго манай судлаач эрдэмтэд англи хэлнийхээ мэдлэг чадварын түвшингээ өөрсдөө хэрхэн үнэлэж байгааг болон, диссертацийн хураангуйд хэр ач холбогдол өгч, түүнийг хэр зэрэг үнэлж, хэрхэн хандаж, ямар арга хэлбэрээр боловсруулж байгааг тандаж мэдэх явдал байсан. Иймээс бид судалгаанд оролцсон судлаачид диссертацийн хураангуй буюу /абстракт/-ыг хэрхэн ойлгож тодорхойлж буйг тандан судлахад тэдний 46,8% нь нэг сэдэвт зохиолын хураангуй, 31,9% нь диссертацийн үндсэн бүлгүүдийн гол агуулгын хураангуй, 17,0% нь нэг сэдэвт зохиолын танилцуулга, 4,3% нь диссертацийн удиртгал, дүгнэлт гэж үзжээ. Үүнийг графикаар харуулбал:



График4. Судлаачид хураангуйг авч үзсэн нь

Судалгаанд хамрагдсан нийт судлаачдын 70% нь хүнээр орчуулуулсан, 30% нь өөрөө орчуулсан гэж хариулжээ. Үүнийг графикаар харуулбал.



Бид судалгааны ажлын зорилгын хүрээнд судлаачдын эрдэм шинжилгээний зохиолын англи хэлний хэрэглээний түвшин ямар байгааг тандан судалж, үр дүнд нь дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Өнөөдөр монголын шинжлэх ухааны салбарт ажиллаж буй эрдэм шинжилгээний зохиол бүтээл туурвиж байгаа эрдэмтэн судлаачдын хэрэглээнд англи хэл нь нэг үндсэн хэрэгслэл, гол хэрэглэгдэхүүн нь болж чадсан боловч судлаачдад тулгамдсан асуудлууд оршсоор байна.

2. Монгол судлаачдын бүтээлийг цаашдаа олон улсын хэмжээнд сурталчлах, дэлхийн шинжлэх ухааны жишигт нийцүүлэн боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.

Экспертүүдээс авсан судалгаа

Эрдэмтэн судлаачдаас авсан санал асуулгын зэрэгцээ мэргэжлийн хэл шинжлэлийн туршлагатай эрдэмтэн багш нартай нэг сэдэвт зохиолын хураангуйг англи хэлээр бичих талаар ганцаарчилан ярилцсан болно. Сурвалжлагын аргаар ШУА, ХУИС, МУИС, Ховд БИС бусад их дээд сургуулийн багш судлаачдыг хамруулан судалгааг явуулсан болно. Дээрх судалгааны үр дүнд бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Нэг сэдэвт зохиолын хураангуйг англи /гадаад/ хэлээр бичих журам чанарын ямар түвшинд хэрэгжиж байгаа тухайд экспертүүдийн дөрвөн хүн тутмаас нэг нь боломжийн түвшинд гэж үзэж байхад, таван хүн тутмын дөрөв нь шаардлага хангахгүй байна гэж үзэж байна.

2. Цаашид хураангуйн бичвэрийг боловсронгуй болгох шаардлага манай шинжлэх ухааны салбарын өмнө тулгамдсан зорилт болж байгаа, энэ нь манай эрдэмтдийн бүтээл олон улсын шинжлэх ухаантай холбогдох, тэднээс суралцах, тэдэнд уншигдан үнэлэгдэх үндсэн арга зам гэдэгтэй экспертүүд санал нэгдэж байгаа бөгөөд тэд цаашид юу анхаарах тухайд дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

- Докторантурын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх
- Хураангуй бичих стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох
- Шинжлэх ухааны салбар бүрээр хураангуй бичих арга зүйн зөвлөмж, аргачлал боловсруулах

- Англи хэлний ур чадвараа дээшлүүлэх талаар судлаачид өөрсдөө олдож байгаа бүх боломжийг англи хэлний зөв бичих дүрмийн програм хангамжийг ашиглаж сурахаас эхлээд гадаадын судлаачтай багш шавийн, найз нөхдийн ёсоор харилцаж тэднээс суралцах гэх мэт ашигладаг байх

- Эрдэмтэд, залуу судлаачдын гадаад харилцаа хамтын ажиллагааг төрөөс бодлоготойгоор дэмжих

- Эрдмийн зэрэг цол хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож нэг нэгдмэл тогтолцоотой болгох, зэрэг цол хамгаалахад тавих шаардлагыг нь өндөрсгөх зэрэг

- Судлаачид хураангуйгаа бичихдээ бусдын тусламж дэмжлэг авдаг нь бодит байдал юм. Тийм учраас орчуулагчид, орчуулгын товчоодыг магадлан итгэмжилдэг журамтай болж болох юм гэсэн саналуудыг экспертүүдийн зүгээс гаргаж байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд манай

шинжлэх ухааны хэлэнд англи хэл голлох хэрэглээ болсныг тэд чухал амжилт гэж үзэхийн хамт, түүнийг улам чанаржуулж боловсронгуй болгох нь тулгамдаж байгаа асуудал гэдэгтэй санал нэгдэж байна. Экспертүүдийн эдгээр санал үндсэндээ манай залуу судлаачдад хандсан тэдэнд зориулагдсанаараа улам их үнэ цэнэтэй юм.

ДҮГНЭЛТ

Бид судалгааны ажлын хүрээнд нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбарын судлаачдын диссертацийн англи хэл дээр бичсэн 30 хураангуйг түүвэрлэн авч, кейс судалгааг хийсэн болно. Энэхүү кейс судалгааг хийхдээ контекст анализын аргыг хэрэглэн, үр дүнд нь боловсруулалт хийлээ.

Хураангуйг бичихдээ бидний гаргадаг түгээмэл алдаа бол гарч буй үр дүнг тусгадаггүй ба зөвхөн удиртгал болон дүгнэлт хэсгийг хэсэгчилэн авч орчуулдаг.

Хамгийн чухал зүйл нь уг судалгааны талаар юу хийснээ тоочих биш ямар шинэ зүйл нээсэн гэдгийг оруулах нь чухал бөгөөд ямар аргаар судалгаа хийснээ оруулна гэдэг бол таны үр дүнг тодорхой болгодог. Тухайн хураангуйн сүүлийн хагас хувь нь тухайн ажлын үр дүнг дүгнэж гаргахад чиглэгддэг. Үр дүн гэдэг бол хамгийн чухал бөгөөд орхиж болохгүй. Судалгааны ажлын явцад бид алдаа үүсэх шалтгааныг тодруулан судалсан юм. Алдаа нь суралцагчийн гадаад хэл сурах дотоод механизмтой холбоотой гэж барууны зарим судлаач тэмдэглэсэн байдаг. 1970-аад онд суралцагчийн гадаад хэл эзэмшихүйн хүрээнд асар их судалгаа хийгдсэн ба суралцагчийн хэл нь түүний эх хэлнээс хамааралгүй системтэй мөн эх хэл эзэмшихүйтэй харьцуулахад олон тооны ижил төстэй зарим ялгаатай талтай үйл явц гэж хүлээн зөвшөөрч эхэлжээ. Харьцуулсан хэл шинжлэлийн үзэл онолоор суралцагчийн гаргаж байгаа алдаа эх хэлний системийн зөрүүтэй байдлаас болж сурч буй гадаад хэлний системд мэдээлэл буруу дамжигдах шалтгаан болдог гэж үздэг.

НОМЗҮЙ

Баттогтох Д. (2007). *Эрдэм шинжилгээний найруулга*, УБ.

Паламдорж Ш. (2009). *Судлахуйн үндэс*. УБ.

Сүхбаатар Ц. (2012). *Монгол хэлний найруулга зүй*. УБ.

Чадрaa Б. (2000). *Монголын Нэвтэрхий толь*. УБ.

About the university (2016). "Nineteenth and twentieth centuries". University of Cambridge. Retrieved October, 31, 2022 from <https://www.cam.ac.uk/about-the-university/history/nineteenth-and-twentieth-centuries>

Ashton, R. (2008). Society for the Diffusion of Useful Knowledge.

Brossard, D., Lewenstein, B., & Bonney, R. (2005). Scientific knowledge and attitude change: The impact of a citizen science project. *International Journal of Science Education*, 27(9), 1099-1121.

Bucchi, M. & Trench, B. (2016). *Who pays for science* Berkeley University.

Carter-Sigglow, J. (1997). Beyond the language barrier. *Nature*, 385(6619), 764-764.

Cline, M. (1987). *Implications for Anglo-German academic communications in English. Strategies in world English*

Clyne, M. (1987). Cultural differences in the organization of academic texts: English and German. *Journal of pragmatics*, 11(2), 211-241.

Durant, J. R., Evans, G. A., & Thomas, G. P. (1989). The public understanding of science. *Nature*, 340, 11-14.

Gliner, J. A., Morgan, G. A., & Leech, N. L. (2011). *Research methods in applied settings: An integrated approach to design and analysis*. Routledge.

Leo Jr, F. (2007). *Pocket Book of Technical Writing for Engineers and Scientists*.

Scheufele, D. A., & Turney, J. (2006). Messages and heuristics: How audiences form attitudes about emerging technologies. *Engaging science: Thoughts, deeds, analysis and action*.

Swales, J. M., & Swales, J. (1990). *Genre analysis: English in academic and research settings*. Cambridge University Press.